

“Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын
Хавсралт 4-а

АЛБАН МЭДЭГДЭЛ

Улаанбаатар хотын бонд

Огноо: 2026.03.26
(0000, cc, өө)

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах Улаанбаатар /нийслэл/ хот-ын үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол Улсын Засгийн газар /Нийслэлийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Бонд гаргагч аймаг/нийслэл хот-ын нэр:	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар
1.2. Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар	2025 оны 12-р сарын 26-ны өдрийн 25/145 дугаартай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол
1.3. Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар	2026 оны 2-р сарын 11-ны өдрийн 49 дугаартай Монгол Улсын Засгийн газрын тогтоол
1.4. Бондын нэр:	Нийслэл бонд
1.5. Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/:	Зэрэглэл тогтоолгоогүй
1.6. Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр /зэрэглэл тогтоолгосон бол/:	Зэрэглэл тогтоолгоогүй
1.7. Тоо ширхэг:	200,000 (хоёр зуун мянга) ширхэг
1.8. Нэрлэсэн үнэ:	1,000,000 (нэг сая) төгрөг
1.9. Хугацаа:	3 жил

0000 00010



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б.Х.
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -03- 24

БҮРТГЭВ-03

1.10. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:

14%, Тогтмол

1.11. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:

Хүү төлөх давтамж: Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх хуваарь:
Хугацааны эцэст

1.12. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/

Байхгүй

1.13. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:

200,000,000,000 (хоёр зуун тэрбум) төгрөг*
**Бондын татан төвлөрүүлсэн үнийн дүнгээс тухай бүр андеррайтерийн шимтгэлийг суутган тооцно*

1.14. Тодорхой үе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол дэлгэрэнгүй мэдээлэл:

Бондыг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 4.1-д заасны дагуу нийтэд санал болгох бондын бүхий л дүнг нэг удаа бүртгүүлж, нэг удаа санал болгоно.

1.15. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:

Бондыг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.2 болон 6.3-т заасны дагуу энэхүү мэдэгдэл дээр тусгасан нөхцөлөөр, Хороонд бүртгүүлснээс хойш 6 сарын дотор анхдагч зах зээлд санал болгоно. Зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулагчдын хандлагыг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдэгдлийг уг үйл ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэж анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

0000 00011



1.16. Үнэт цаасаар гэрчлэгдэх хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг:

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б.
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026-03-24

Бонд эзэмшигчийн эрх, үүрэг:

- Анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй худалдах эрхтэй.
- Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй бөгөөд тус эрхээ өөрөө эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан эдэлнэ.
- Бондтой холбоотой аливаа санал, гомдлыг Андеррайтерт мэдэгдэнэ.
- Бонд эзэмшигч нь хуулиар хүлээсэн татвар, арилжааны шимтгэл болон бусад гарах зардлыг өөрөө хариуцна.
- Бонд эзэмшигчийн бондын захиалгын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
- Бондын үндсэн нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, албан мэдэгдэл болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
- Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

1.17. Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч "Улаанбаатар хот"-ын бонд санал болгон гаргах ажиллагаанд 2026 оны 02 сарын 12-ны өдөр андеррайтерийн гэрээ байгуулсан. "Андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний хүрээнд талууд дараах эрх, үүрэгтэй байна:

Зөвлөх /Андеррайтер/-ийн эрх, үүрэг:

- Захиалагчийн үнэт цаасны данс нээх, бүртгүүлсэн үнэт цаас байршуулах ажлыг зохион

0000 00012



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -03- 24


- байгуулах зэргээр брокерийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт болон арилжааг гүйцэтгэх үүрэгтэй.
- Зөвлөх, түүний ажилтнууд нь гэрээнд заасан үйл ажиллагаатай холбоотойгоор эрх бүхий байгууллага, хөрөнгө оруулагчдад зайлшгүй хүргэх шаардлагатай мэдээллээс бусад бизнесийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийг нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.
- Зөвлөх нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай захиалагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг захиалагчаас гаргуулан авах боломжтой.

Захиалагч /Үнэт цаас гаргагч/-ийн эрх, үүрэг:

- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.
- Захиалагч нь аливаа бэлтгэн өгч буй мэдээллийг үнэн зөвийг хариуцах ба уг үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн хохирлыг хариуцна.
- Захиалагч нь эрх бүхий этгээдийн баталсан үнэт цаасны нөхцөлийн дагуу үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
- Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

0020 00013



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -03- 24

БҮРТГЭВ-03

1.18. Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр:

☒ Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох;

☐ Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох

/Андеррайтертай гэрээ байгуулсан бол. Дараах аргын аль нэгийг сонгоно уу/

☐ Захиалгын бүртгэлийн арга

☐ Тогтсон үнийн арга

☐ Бонд гаргагч дангаар олон нийтэд санал болгох

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Улаанбаатар /Нийслэл/ хот нь олон нийтэд санал болгон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

2.1.1. Үйл ажиллагаа – 1 /Бусад үйл ажиллагааг мөн агуулгын дагуу бичнэ үү/

2.1.1.1. “Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай” хуулийн дагуу хэрэгжүүлж буй “Тавдугаар дулааны цахилгаан станц” төсөл. Нийт хөрөнгө оруулалтын 20%-ийг нийслэл, 80%-ийг хувийн хэвшил санхүүжүүлнэ.

2.1.1.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь [%]: 200 тэрбум төгрөг буюу 100%

2.1.1.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: 2026 оны 4-р сараас 2029 оны 4-р сар хүртэл нийт 36 сар

2.1.1.4. Хэрэгжүүлэгч этгээд:

- ☒ Орон нутаг;
- ☐ Хувийн хэвшил;
- ☐ Төр, хувийн хэвшлийн түншлэл.

2.1.1.5. Бэлэн байдлын үнэлгээ:

- ☒ Зураг төсөл;
- ☒ Техник, эдийн засгийн үнэлгээ;
- ☒ Байгал орчны нөлөөллийн үнэлгээ;
- ☒ Туслан гүйцэтгэгч;
- ☐ Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт;
- ☐ Шаардлагатай бусад

0000 000014

2026 -03- 24

БҮРТГЭВ-03

2.1.1.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл

Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

4.2.8. Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.

8.1.6. Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.

9.3.6. Хотын гудамж замын иж бүрэн сүлжээг бий болгоно.

Нийслэлийн 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

5.8. Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

6.2.2. Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

2020 оноос 2024 он хүртэл Монгол улсын нийт эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 7%-иар өссөн бол эрчим хүчний нийт үйлдвэрлэл 5%-иар өссөн байна. Монгол улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөлт, хэрэглээний өсөлтөөс бага байгаа нь эрчим хүчний хомсдол болон импортын эрчим хүчний эрэлтийг өсгөж байна. ДЦС-5 төслийн цахилгаан эрчим хүчний Үйлдвэрлэл 270 МВт байх ба энэ нь эрчим хүчний салбарын дутагдлын нөхөхийн сацуу шугам сүлжээний тогтвортой байдлыг сайжруулна. Нөгөө талаар жижиг халаагуурын зуухнуудыг цахилгаан станцын уурын халаагуурын системээр сольсноор агаарын бохирдлыг их хэмжээгээр бууруулж нийслэлийн агаарын чанар болон оршин суугчдын ая тухтай байдлыг хангах боломжтой болно.

Хүрэх үр дүн:

- ДЦС-5 нь ДЦС-2-ээс 400м-ийн зайд байрлах бөгөөд ЭБҮШ-тай 2 зуух, завсрын халаалттай өндөр даралтын 2 турбин генератортай баригдахаар байна. Тухайн станц нь Багануур болон Шивээ-Овоогоос нүүрс худалдан авах ба блок бүр нь 135 МВт цахилгаан эрчим хүч түгээх ба нийт 270 МВт түгээнэ. Тухайн дулааны станц нь Улаанбаатар хотод үүсээд буй эрчим хүчний тогтворгүй байдлыг багасгах бөгөөд бусад дулааны станцаас бага агаарын бохирдол үүсгэх юм.

Учирч болзошгүй эрсдэл:

- Байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлсээс хамаарч төсөл удаашрах, зардал нэмэгдэх.

СЭХ

2026-03-24
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026-03-24

Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.2-т заасны дагуу Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь улсын бүртгэлийн гэрчилгээнд заасны дагуу "Засаг даргын бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилгыг биелүүлэхэд чиглүүлж, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын хамтын ажиллагааг ханган нутгийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх" үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлнэ.

2.3 Хориглох үйл ажиллагааны жагсаалт

Нийслэл нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

Улаанбаатар хот /Нийслэл/ нь Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.4.5-д заасны дагуу энэхүү мэдэгдэлд тусгасан төсөл, арга хэмжээ болон бонд гаргахтай холбоотой гарах зардлаас бусад үйл ажиллагааг тус бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

2.4 Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл

Нийслэл нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын хэлтэс төсөл тус бүрээр тайлагнаж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь бондын хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

2.5 Шаардлагатай бусад мэдээлэл:

0000 00016



3 Тайлагнал

3.1 Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж

Тайлангийн нэр: Зарцуулалтын тайлан

Олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж:

Нийслэл нь бондын арилжааг хийсэн өдрөөс тухайн бондын хугацаа дуусах хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын хавсралт 8-д тусгасан маягтуудын дагуу улирал тутамд дараа сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 сарын 10-ны дотор, Хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

3.2 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд

Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний явц, үе шат, үр дүнг дараах журмын хүрээнд холбогдох хэлтсүүд үнэлэн, хяналт тавьж, нийтэд мэдээлж ажиллана.

- Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын “Хяналт шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам” мөн “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” болон “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-д заасны дагуу хяналт шалгалт, үнэлгээ хийнэ.
- “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам” нь Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, нийслэлийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.6-д тусгасны дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах мэдэгдэлд энэхүү баримт бичигт тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан мэдээллийг хавсарган Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, нийтэд тухай бүр мэдээлнэ.

3.3 Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

Овог нэр: Л.Эрдэнэбадрах

Албан тушаал: НЗДТГ-ын СХОГ-ын дарга

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, вега сити, 401 тоот

Утас: +976-99090549

Цахим хаяг: erdenebadrakh.l@ulaanbaatar.mn

0000 00017




БАТАЛГААЖУУЛСАН:

Овог, нэр: **Хишгээ НЯМБААТАР**

Албан тушаал: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатарт хотын Захирагч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)



Овог, нэр: **Хүрлээ МӨНХЗУЛ**

Албан тушаал: “Эм Ай Си Си ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)



Овог, нэр: **Түвдэнбямба ОЮУНЧИМЭГ**

Албан тушаал: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **Ганбат ХҮСЛЭН**

Албан тушаал: “Эм Ай Си Си ҮЦК” ХХК-ийн ахлах шинжээч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **Лхагвадорж ЭРДЭНЭБАДРАХ**

Албан тушаал: Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

0000 00018



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИР
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -03- 24

БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Нийслэлийн дотоод үнэт цаас гаргах
зөвшөөрөл олгох тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)" төслийг санхүүжүүлэх зорилгоор 200 0 (хоёр зуу) тэрбум төгрөг хүртэлх нийслэлийн үнэт цаасыг хууль тогтоомжид нийцүүлэн дотоодын зах зээлд 2026 онд багтаан төслийн хэрэгжилттэй уялдуулан үе шаттайгаар арилжаалахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт зөвшөөрсүгэй.

2. Нийслэлийн үнэт цаас арилжаалах замаар төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг нийслэлийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хуваарийн дагуу төлж барагдуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

0000 00019



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -03- 24

БҮРТГЭВ-03



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 25/145

Улаанбаатар хот

Нийслэлийн дотоод үнэт цаас
гаргахыг дэмжих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйл, Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 28¹ дүгээр зүйлийн 28¹.6.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоолоор баталсан "Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам"-ыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Алсын хараа-2050" болон нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2026 онд 275.0 тэрбум төгрөгийн нийслэлийн үнэт цаасыг гаргаж дотоодын зах зээлд арилжаалах талаар Нийслэлийн Засаг даргаас гаргасан саналыг дэмжсүгэй.

2. Нийслэлийн дотоод үнэт цаасаар арилжсан мөнгөн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэн, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, зөвшөөрлийн хамт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар эргэн хэлэлцүүлж батлуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

0778:00026